

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийн эрүүл мэндийн даатгалын гэрчилгээг ашиглах тухай


Монгол хувилбар (2025 оны 7-р сарын байдлаар)

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Даатгалын газар

Ministry of Health, Labour and Welfare of Japan

Японы эрүүл мэндийн даатгалын тогтолцооны тойм

Японы эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд хамрагдах бүх иргэд даатгалын шимтгэл төлснөөр, тодорхой хэмжээний өөрөө хариуцах төлбөрийг төлсний үндсэн дээр эмчилгээ үйлчилгээ авах боломжтой. Хамрагдах иргэдэд Япон улсын иргэдээс гадна оршин суух хугацаа нь 3 сараас дээш байх хүн зэрэг тодорхой шалгуурыг хангах гадаадын иргэд ч хамаарна. Эмчилгээ үйлчилгээ бодитоор авах үед аль эмнэлгийн байгууллага, эмийн санд үзүүлэх талаар хамрагдах иргэд чөлөөтэй сонгох боломжтой.



Эмнэлгийн байгууллага, эмийн санд үйлчлүүлэх арга

Миний дугаар үнэмлэх (My Number Card) зэргээр даатгалын эрхийг баталгаажуулснаар 10-30%-ийн төлбөрийг өөрөө хариуцан үйлчлүүлэх боломжтой.

Эмнэлгийн байгууллага, эмийн санд эрүүл мэндийн даатгалын эрх баталгаажуулах

Эмнэлгийн байгууллага, эмийн сангаар үйлчлүүлэхдээ,

- Миний дугаар үнэмлэх (My Number Card)
- Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ *
- Даатгалын эрхийн баталгааны үнэмлэх *

эдгээрийн аль нэгээр даатгалын эрхийг баталгаажуулна.

(*) Миний дугаар үнэмлэх (My Number Card) байхгүй эсвэл эрүүл мэндийн даатгалын гэрчилгээгээр бүртгүүлээгүй бол эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ (Хамгийн уртдаа 2025 оны 12-р сарын 1 өдөр хүртэл) эсвэл даатгалын эрхийн баталгааны үнэмлэх (2024 оны 12-р сарын 2 өдрөөс хойш хэвлэсэн) ашиглаж болно.

Ингэснээр, эмчилгээ үйлчилгээний бодит гарсан төлбөрийн 100%-г өөрөө төлөхгүйгээр, **6- 69 насны иргэд 30%-г** өөрөө хариуцан үйлчлүүлж болно.

Бусад хүмүүс ч нас, орлогоосоо хамаараад 10%, 20%, 30% төлж үйлчлүүлэх боломжтой.

Миний дугаар үнэмлэх (My Number Card)

Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ (- 2025 оны 12-р сарын 1 өдөр хүртэл)

Даатгалын эрхийн баталгааны үнэмлэх (2024 оны 12-р сарын 2 өдрөөс хойш)

Миний дугаар үнэмлэх (My Number Card) хэрхэн авах тухай

Миний дугаар үнэмлэх (My Number Card) авах өргөдөл гаргах 4 арга байдаг.

Ухаалаг утас (зөвхөн Япон хэл)

1. Ухаалаг гар утсаар нүүрний зураг авах (Бүрдүүлэлтийн явцад зураг авах боломжтой.)
2. Ухаалаг утсаар Хувийн дугаарын мэдэгдэл хуудасны **Хүлээн авах хүсэлтийн QR код**-ийг уншуулна
3. Гарч ирэх хүсэлт гаргагчийн цахим хуудсанд и-мэйл хаяг зэргийг бүртгүүлнэ
4. И-мэйл хаягт хүсэлт гаргагчийн цахим хуудасны URL (холбоос) ирмэгц, нүүрний зураг оруулах, шаардлагатай мэдээллийг оруулснаар хүсэлтийг дуусгана




Цээж зураг авах машин

1. Даралтат дэлгэцээс "Хувийн дугаарын үнэмлэх авах хүсэлт"-ийг сонгоно
2. Зураг авах хураамжийг хийгээд, Хувийн дугаарын мэдэгдэл хуудасны **Хүлээн авах хүсэлтийн QR код**-ийг бар код уншигчаар уншуулна.
3. Дэлгэц дээрх зааврыг дагаж, шаардлагатай мэдээллийг оруулна
4. Дэлгэц дээрх зааврыг дагаж, нүүрний зураг дарж илгээснээр хүсэлтийг дуусгана




Компьютер (зөвхөн Япон хэл)

1. Дижитал камер ашиглан нүүрний зураг авах
2. Хүсэлтийн цахим хуудас * дээр **Хүсэлтийн маягтын дугаар (23 оронтой)** оруулаад и-мэйл хаягаа бүртгүүлнэ
3. Хүсэлт гаргагчийн цахим хуудасны URL (холбоос) ирмэгц, нүүрний зураг оруулаад, шаардлагатай мэдээллийг оруулснаар хүсэлтийг дуусгана
*(<https://net.kojinbango-card.go.jp/>)



Шуудан

1. Хувийн дугаарын мэдэгдэл хуудсанд хавсаргасан **Хүлээн авах хүсэлтийн маягтад шаардлагатай мэдээллийг оруулж, сүүлийн 6 сарын дотор** авахуулсан нүүрний зургийг наана
2. Хамт ирсэн хариу илгээх дугтуйнд хийгээд шуудангаар илгээж, хүсэлтийг дуусгана



Хүлээн авах
хүсэлтийн маягт

Нүүрний зураг

Хариу илгээх
дугтуй

Япон хэлнээс бусад хэл дээрх Миний дугаар үнэмлэх (My Number Card) хүлээн авах хүсэлтийн маягтын тухайд цахим хуудаснаас шалгана уу

Цахим хуудсанд хандахын тулд QR кодыг уншуулна уу



* Хүсэлтийн маягт татаж авах болон Миний дугаар үнэмлэх (My Number Card)-тэй холбоотой мэдээллийг дараах цахим хуудаснаас шалгана уу.
(Япон хэл, Англи хэл, Хятад хэл, Солонгос хэл, Испани хэл, Португали хэлээр боломжтой)

<https://www.kojinbango-card.go.jp/>

(1) Эмнэлгийн байгууллага, эмийн санд бүртгүүлэх

Шаардлагатай зүйлс

- 1
- Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийг даатгалын гэрчилгээгээр бүртгүүлэх
- マイナンバーカード
を保険証として登録
- マイナンバーカードを保険証
として利用するための登録が
必要です。
- Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийг даатгалын гэрчилгээгээр хэрэглэхийн тулд бүртгүүлэх шаардлагатай
- 登録せずに終了
- Бүртгүүлэхгүйгээр дуусгах
- 登録する
- Бүртгүүлэх

2

Даатгалын гэрчилгээгээр бүртгүүлэх

保険証として登録

終了する

次へ進む

Зөвшөөрч үргэлжлүүлэх

3

Амжилттай бүртгэгдлээ

登録が完了しました

マイナンバーカードを保険証として利用できます。

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийг даатгалын гэрчилгээгээр ашиглаж болно.

次へ

Цааш нь

5

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийн эрүүл мэндийн даатгалын гэрчилгээг ашиглахаар бүртгүүлэх

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийг эрүүл мэндийн даатгалын гэрчилгээгээр ашиглахын тулд бүртгэл хийлгэх шаардлагатай. Бүртгүүлэх тал дараах байдалтай байдаг.

(2) Май на портал (Mynportal)-д урьдчилан бүртгүүлэх

Шаардлагатай зүйлс

- Миний дугаар үнэмлэх (My Number Card)
- Хэрэглэгчийн баталгаажуулалтын нууц үг
- Ухаалаг утас
- Май на портал (Mynportal) апп суулгах

Бүртгэлийн дараалал

* Дэлгэцийн зургийн дагуу дараах дарааллаар бүртгүүлнэ үү.

- ① Май на портал (Mynportal) апп нээж нэвтрэн, "Гэрчилгээ"-р "Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ"-г сонгоно.
- ② "Миний дугаар үнэмлэх (My Number Card) ашиглах" нь улаан өнгөтэй бөгөөд "Бүртгүүлээгүй" гэсэн байвал "Бүртгүүлэх"-ийг сонгоно.
- ③ Бүртгэлд цаг шаардагдах тохиолдолд "Бүртгүүлж байна" гэсэн бичиг гарч ирнэ.
- ④ "Миний дугаар үнэмлэх (My Number Card) ашиглах" нь "Бүртгэгдсэн" төлөвтэй болбол ашиглах бүртгэл дууссан болно.

[Дэлгэцийн зураг]

Май на портал (Mynportal)-д нэвтрэх

- "Май на портал (Mynportal) апп"-ийг суулгана
- Нэвтрэхэд хүсэлт гаргагчийн өөрийн Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийг ашиглах

iOS




Android




2 хэмжээт бар код уншихгүй байвал "Май на портал (Mynportal)"-р хайлт хийнэ үү.



(1) **Май на портал (Mynportal) апп нээж нэвтрэн, "Гэрчилгээ"-р "Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ"-г сонгоно.**



(2) **"Миний дугаар үнэмлэх (My Number Card) ашиглах" нь улаан өнгөтэй бөгөөд "Бүртгүүлээгүй" гэсэн байвал "Бүртгүүлэх"-ийг сонгоно.**



(3) **Бүртгэлд цаг шаардагдах тохиолдолд "Бүртгүүлж байна" гэсэн бичиг гарч ирнэ.**



(4) **"Миний дугаар үнэмлэх (My Number Card) ашиглах" нь "Бүртгэгдсэн" төлөвтэй болбол ашиглах бүртгэл дууссан болно.**



My number үнэмлэхээр эмнэлэгт үйлчлүүлэх арга

* Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээний ашиглах бүртгэл хийлгэсэн Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ээр эмнэлгийн байгууллага, эмийн сангаар үйлчлүүлэхдээ царай таних функц бүхий карт уншигчаар * хувь хүнийг баталгаажуулах болон даатгалын эрхийн баталгаажуулна. Царай таних функцтэй карт уншигч нь Миний дугаар үнэмлэх (My Number Card) дээрх нүүрний зурган мэдээллийг IC чипээс уншиж, тухайн "Нүүрний зурган мэдээлэл" болон харилцах цонх дээр авсан "Тухайн хүний цээж зураг"-тай харьцуулан хувь хүний баталгаажуулалт хийх чадвартай карт уншигч юм.

Эмнэлэгт ирэх

Хувь хүний баталгаажуулалт

Зөвшөөрлийн зүйлсийг баталгаажуулах

Хүлээн авч дууссан

① Миний дугаар үнэмлэх (My Number Card)



Царай таних функц бүхий карт уншигчийн төрлүүд



② Хувь хүнийг баталгаажуулах аргыг сонгох

Царай таних



ПИН код (4 оронтой)



* Дугаарын байрлал өөрчлөгдөнө

③ Эмчилгээ үйлчилгээ, эм бэлдмэл, эрүүл мэндийн тусгай үзлэгийн мэдээлэл зэргийн ашиглалтын талаар баталгаажуулах, сонгох

* Цахим жор гэх мэт бусад баталгаажуулах зүйлс болон зөвшөөрлийн зүйлс хамарсан байж болно.

Өнгөрөгч хугацааны эмнэлгийн үйлчилгээ зэргийн мэдээлэл өгөхийг зөвшөөрч байна уу.

過去の医療情報等の提供に同意しますか。

【手術／診療、お薬／健診】

[Мэс засал/Эмчилгээ үйлчилгээ/Эм/Эрүүл мэндийн үзлэг]


Бүгдийг зөвшөөрөх

全て同意する

Хэсэгчлэн зөвшөөрөх

個別に同意する

④ Доорх дэлгэц гарч ирвэл хүлээн авч дууссан болно.



Картаа гаргаж аваад хүлээлгийн өрөөнд хүлээнэ үү.

Зөвшөөрлийн зүйлсийн тухай

Царай таних функц бүхий карт уншигч ашиглан бүртгүүлэхдээ, өнгөрөгч хугацаанд олгогдсон эм бэлдмэл болон эрүүл мэндийн тусгай үзлэг зэргийн мэдээллийг эмч болон эмийн санчид зөвшөөрөл өгөх эсэхийг баталгаажуулна.

Зөвшөөрлийн аргын баталгаажуулалт

過去の医療情報等の提供に同意しますか。【手術 / 診療、お薬 / 検診】

Өнгөрөгч хугацааны эмнэлгийн үйлчилгээ зэргийн мэдээлэл өгөхийг зөвшөөрч байна уу? [Мэс засал/Эмчилгээ үйлчилгээ, Эм/Эрүүл мэндийн үзлэг]

Бүгдийг зөвшөөрөх

全て同意する

Хэсэгчлэн зөвшөөрөх

個別に同意する

● Хэсэгчилсэн зөвшөөрлийн дэлгэц

Мэс засал

過去の手術情報を、当機関に提供することに同意しますか。

Өнгөрөгч хугацааны мэс заслын мэдээллийг тус байгууллагад өгөхийг зөвшөөрч байна уу?

Зөвшөөрөх

同意する

Зөвшөөрөхгүй

同意しない

Мэс заслын бус эмчилгээ үйлчилгээ болон эмийн мэдээлэл

過去の手術以外の診療・お薬情報を、当機関に提供することに同意しますか。

Өнгөрөгч хугацааны мэс заслын бус эмчилгээ үйлчилгээ, эмийн мэдээллийг тус байгууллагад өгөхийг зөвшөөрч байна уу?

Зөвшөөрөх

同意する

Зөвшөөрөхгүй

同意しない

Эмийн мэдээлэл

過去のお薬情報を当機関に提供することに同意しますか。

Өнгөрөгч хугацааны эмийн мэдээллийг тус байгууллагад өгөхийг зөвшөөрч байна уу?

Зөвшөөрөх

同意する

Зөвшөөрөхгүй

同意しない

Эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл

過去の健診情報を、当機関に提供することに同意しますか。

Өнгөрөгч хугацааны эрүүл мэндийн үзлэгийн мэдээллийг тус байгууллагад өгөхийг зөвшөөрч байна уу?

Зөвшөөрөх

同意する

Зөвшөөрөхгүй

同意しない

* Дэлгэцийн дизайн болон харагдах текст нь байгууламж болон үйлдвэрлэгчээс хамааран ялгаатай байж болно.

Бүгдийг зөвшөөрөх

Өнгөрөгч хугацааны эмнэлгийн үйлчилгээ зэргийн бүх мэдээллийг өгөөд асуудалгүй бол дээрх товчийг сонгоно уу. **Зөвшөөрлүүдийг нэгтгэн дуусгавар болгоно.**

Хэсэгчлэн зөвшөөрөх

Өгөх мэдээллийг ялгаж өгөх тохиолдолд доорх товчийг сонгоно уу. Үүний дараа мэс засал болон эмийн мэдээлэл, эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл зэргийг өгөхтэй холбоотой дараалал харагдах тул Хэсэгчлэн зөвшөөрөхийг сонгоно уу.

Зөвшөөрлийн зүйлсийн тухай

(Нэг эмнэлгийн байгууллага, эмийн санд дахин очиж үйлчлүүлсэн бол)

Хүлээн авах үеийн карт уншигчийн зөвшөөрөл авах дэлгэцийн тухайд, өмнө нь үйлчлүүлж байсан эмнэлгийн байгууллага, эмийн санд **дахин очиж үйлчлүүлсэн** үед, тухайн байгууламжид хэсэгчлэн бүртгүүлсэн өмнөх зөвшөөрлийн төлөв байдлыг үргэлжлүүлэн ашиглах боломжтой.

* Зөвшөөрлийн төлөв байдлыг бусад эмнэлгийн байгууллага, эмийн санд өгөхгүй.



Хэсэгчлэн зөвшөөрөх тохиолдолд өмнөх зөвшөөрлийн мэдээллийг үргэлжлүүлэн ашиглах боломжтой.

- ①: "Хэсэгчлэн зөвшөөрөх"-өөр өмнөх зөвшөөрлийн төлөв байдлыг шалгах болон өөрчлөх боломжтой.
- ②: Өнгөрөгч хугацаанд бүртгэгдсэн зөвшөөрлийн мэдээлэл байгаа тохиолдолд тухайн зөвшөөрлийн төлөв байдлын талаар шалгах боломжтой.
- ③: "Одоогийн зөвшөөрлийн мэдээллийг үргэлжлүүлэх"-ээр өмнөх зөвшөөрлийн мэдээлэлтэй ижил агуулгын зөвшөөрөл дуусгавар болгоно.
- ④: "Дахин сонгох"-оор өмнөх зөвшөөрлийн мэдээллээс өөрчлөх боломжтой (Энэ удаагийн ирсэн эмнэлэг, эмийн санд холбоотой зөвшөөрлийн мэдээлэл болно.).

*Дэлгэцийн дизайн болон харагдах текст нь байгууламж болон үйлдвэрлэгчээс хамааран ялгаатай байж болно.

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ээр үзлэг хийлгэх давуу тал

Миний дугаар үнэмлэх (My Number Card) ашиглан үзлэг хийлгэхийн гол давуу тал нь дараах байдалтай байна.



Өгөгдөл дээр үндэслэн илүү сайн эмнэлгийн үйлчилгээ авах

Эм бэлдмэлийн мэдээлэл өгөхийг зөвшөөрвөл эмийн дэвтэр үзүүлэхгүйгээр өнгөрөгч хугацаанд олгогдсон эм болон эрүүл мэндийн тусгай үзлэг зэргийн мэдээллийг анх удаа үзүүлж байсан ч эмч, эмийн санчтай төвөггүй хуваалцаж чадна.



Бүрдүүлэлт хийлгүйгээр өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын дээд хязгаараас давсан төлбөр төлөхөөс чөлөөлөгдөх.

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ээр даатгалын эрхийн баталгаажуулалт хийгдэх тул цаасан магадалгаа авч ирэлгүй, мөн бүрдүүлэлт хийх шаардлагагүйгээр өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын дээд хязгаараас давсан төлбөр төлөхөөс чөлөөлөгдөнө.


"Өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын тогтолцоо" гэж юу вэ?

Өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын тогтолцоо нь тухайн эмнэлгийн байгууллага, эмийн сангийн харилцах цонхонд нэг сарын дотор (сарын эхнээс төгсгөл хүртэл) төлсөн төлбөрийн хэмжээ дээд хязгаараас давсан тохиолдолд, тэрхүү давсан мөнгөн дүнг нөхөн олгох тогтолцоо юм. Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийн даатгалын эрхийн баталгаажуулалтаар өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоонд хамрагдана.

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ээр хүлээн авах боломжгүй байх тохиолдолд

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийг эрүүл мэндийн даатгалын гэрчилгээгээр ашиглах үед царай таних функц бүхий карт уншигчийн доголдол зэрэг ямар нэг шалтгааны улмаас даатгалын эрхийн баталгаажуулалт хийж чадахгүй байх тохиолдолд ч дараах замаар даатгалын эрхийн баталгаажуулалт хийгдэнэ.

Ингэснээр өөрийн хариуцах төлбөрийн 100% бус, өнөөг хүртэл өөрийн хариуцаж байсан төлбөрийн хэмжээгээр үзүүлэх боломжтой болно.




Миний дугаар үнэмлэх (My Number Card) өгсөн боловч
хүлээж авч чадаагүй

Доорх хоёрын аль нэгийг өгч чадах тохиолдолд

Май на портал (Mynportal)-ийн дэлгэц


*Май на портал (Mynportal)-аас татаж авсан PDF файл байж ч болно.




+



Даатгалын эрхийн мэдээллийн тухай мэдэгдэл



+



Зүүн гар талын алийг нь ч өгч чадахгүй тохиолдолд

Дахин үзүүлэх тохиолдолд


Амаар баталгаажуулах

Байгууллага нь даатгалын эрхийн баталгаажуулалт хийхэд шаардлагатай мэдээллүүдийг мэдэж байх тохиолдолд ажилтан нь амаар баталгаажуулна




Анх үзүүлэх тохиолдолд

Даатгуулагчийн даатгалын эрхийн өргөдөл



+



*Ажилтнаас маягт авч бөглөнө үү

"Даатгалын эрхийн мэдээллийн тухай мэдэгдэл" гэж юу вэ?

Мун даатгалын гэрчилгээтэй хүнд хүсэлтээс үл хамааран олгогддог бичиг баримт юм. Дангаараа эмнэлэгт үйлчлүүлэхэд хангалтгүй. Ямар нэг шалтгаанаар даатгалын эрхийн баталгаажуулалт хийж чадаагүй тохиолдолд Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийн хамтаар өгнө үү.

"Даатгуулагчийн даатгалын эрхийн өргөдөл" гэж юу вэ?

Анх удаа эмнэлгийн байгууллага, эмийн сангаар үйлчлүүлэхэд ямар нэг шалтгаанаар даатгалын эрхийн баталгаажуулалт хийж чадаагүй, мөн Май на портал (Mynportal)-ийн дэлгэц болон даатгалын эрхийн мэдээллийн тухай мэдэгдэл биедээ авч яваагүй үед бөглүүлэх бичиг баримт юм.

Дуудлагын төвийн тухай (Гадаад хэлээр хүлээн авна)

Миний дугаар үнэмлэх (My Number Card)-ийн тухай мэдэхгүй зүйл болон санаа зовоох зүйл байгаа бол доорх дуудлагын төвтэй утсаар холбогдож лавлана уу.

* Андуурсан дуудлагын тоо нэмэгдэж байна. Утсаар залгаахаас өмнө дугаараа дахин нэг нягтлана уу.

- ① Миний дугаар үнэмлэх (My Number Card), хувийн дугаарын мэдэгдэл хуудас, мэдэгдэл картын тухай
- ② Миний дугаар үнэмлэх (My Number Card) ба цахим гэрчилгээг суулгасан ухаалаг утас алга болгох, хулгайд алдах зэргээс үүдэлтэйгээр ашиглалтыг түр зогсоох



0120-0178-27

Хүлээн авах цаг

Англи хэл, Хятад хэл, Солонгос хэл, Испани хэл, Португали хэл

Бүх өдөр 8:30-20:00

Тайланд хэл, Балба хэл, Индонез хэл, Вьетнам хэл, Тагалог хэл

Бүх өдөр 9:00-18:00

※ ②-д заасан ашиглалтыг түр зогсоох үйлчилгээг 24 цагийн турш өгнө.

※ Дээрх дугаар холбогдохгүй бол: **0570-064-738** (Төлбөртэй)

※ Дээрх дугааруудын аль нь ч холбогдохгүй бол: **050-3818-1250** (Төлбөртэй)

※ Япон хэлээр үйлчилгээ авахыг хүсвэл: **0570-783-578** (Төлбөртэй)
Хүлээн авах цаг өдөр бүр 8:30-20:00

My number хөтөлбөр, Май на портал (Mynaportal)



0120-0178-26

Хүлээн авах цаг

Англи хэл, Хятад хэл, Солонгос хэл, Испани хэл, Португали хэл, Тайланд хэл, Балба хэл, Индонези хэл, Вьетнам хэл, Тагалог хэл

Ажлын өдөр 9:30-20:00

Амралтын болон баярын өдөр 9:30-17:30

※ Шинэ жилийн амралтын өдрүүд (12-р сарын 29 өдрөөс 1-р сарын 3 өдөр) хамаарахгүй